



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 07

Баянтал сум

Сумын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх
тэргүүлэх чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тогтоолоор батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.10, 2.11, 2.12, 3.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Төсөл сонгон шалгаруулах товыг журмын дагуу 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахаар тогтоосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллан, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Б.Ганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн
07 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт



“Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2.1-т заасны дагуу сумын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл

1. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр
 - Төмс, хүнсний ногоо тариалалт
 - Хүлэмжийн аж ахуй
 - Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - Нийтийн хоол үйлдвэрлэл
 - Талх, нарийн боовны үйлдвэрлэл
 - Арьс, ширэн эдлэл боловсруулах үйлдвэрлэл
 - Гахай, тахианы аж ахуй
 - Мах, сүүний чиглэлээр эрчимжсэн фермерийн аж ахуй
 - Жимс, жимсгэнэ тариалах, мод үржүүлэх
 - Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 - Мал аж ахуйн гаралтай Түүхий эд хүлээн авах, борлуулах нэгдсэн цэг байгуулах, өргөтгөх
 - Цагаан идээ борлуулах нэгдсэн цэг байгуулах
2. Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр
 - Оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэр
 - Мод, модон эдлэл
 - Хоёрдогч түүхий эд хүлээн авах, борлуулах цэг байгуулах
 - Сав баглаа боодол үйлдвэрлэл
3. Нийтийн ахуй үйлчилгээний чиглэлээр
 - Халуун ус, саун
 - Үсчин
 - Зурагчин
 - Зочид буудлын үйлчилгээ
4. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр
 - Блок, тоосго үйлдвэрлэл
 - Зам талбайн хавтан, хашлага, хашаа үйлдвэрлэл
5. Авто машин засвар
 - Авто засвар
 - Автомашины угаалгын газар